ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/06 Сайншанд

Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдөөс ТОГТООХ нь :

1. Гэр бүлийн болон нийгмийн бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгж болох гэр бүл, хүүхэд хамгааллын хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч: Сумын Засаг дарга
Гишүүд: Засаг даргын орлогч
Засаг даргын Тамгын газрын дарга
Сайншанд багийн Засаг дарга
Хоолт багийн Засаг дарга
Бүйлсэн багийн Засаг дарга
Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Сумын хэсгийн Төлөөлөгч
Сумын хэсгийн Цагдаа
Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн
Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан
Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан
20 дугаар цэцэрлэгийн Арга зүйч багш
Нарийн бичгийн дарга: Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан

2. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг сумын хэмжээнд удирдан зохион байгуулж үр дүнтэй үйл ажиллагаа явуулахыг хамтарсан багийн ахлагч, гишүүдэд даалгасугай.

3. Хамтарсан багийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг Хамтарсан багт үүрэг болгосугай.

4625013013

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 03 дугаар сарын 17-ний өдрийн 41 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА  Ч.ОГТБИШ